



**МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

**2008 оны 3 дугаар  
сарын 28-ны өдөр**

**Дугаар 77**

**Улаанбаатар  
хот**

**Арилжааг зогсоосон компанийн талаар  
авах зарим арга хэмжээний тухай**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 21.5 дахь заалт, Хорооны 2008 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилт, улсын ахлах байцаагчийн 2008 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 33, мөн сарын 26-ны өдрийн 36 тоот албан шаардлагыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1.Хавсралтад заасан 165 ХК-ийн арилжааг түр зогсоосон улсын ахлах байцаагчийн шийдвэрийг бүрэн үндэслэлтэй гэж үзэж, эдгээр ХК-ийн үнэт цаасны арилжааг үргэлжлүүлэн түр зогсоосугай.

2.Арилжаа зогсоосон ХК-ийн талаарх мэдээллийг дахин 3-аас доошгүй удаа нийтэд мэдээлэх, веб сайтад тогтмол тавьж байхыг Ажлын алба /О.Ганбат/, Монголын хөрөнгийн бирж /Р.Содхүү/-д үүрэг болгосугай.

3.Эдгээр ХК-ийн бүртгэлийн талаар цаашид авах арга хэмжээний тухай санал, үндэслэлээ 5 дугаар сарын 15-ны дотор Хороонд ирүүлэхийг Монголын хөрөнгийн бирж /Р.Содхүү/-д үүрэг болгосугай.

4.Эдгээр компаниас арилжаагаа сэргээх, эсхүл хувь нийлүүлэгчдийн хурлаас өөрчлөн байгуулагдах, татан буулгах шийдвэр гаргаж, үнэт цаасаа бүртгэлээс хасуулах хүсэлтээ ирүүлсэн тохиолдолд дараах байдлаар хянаж, Хороонд саналаа оруулж байхыг Ажлын алба /О.Ганбат/-нд үүрэг болгосугай.

4.1. Дараах шаардлагыг хангасан ХК-иуд өөрийн хүсэлтээ гаргасан тохиолдолд арилжааг сэргээх саналыг Хорооны хуралдаанд оруулах:

а/үйл ажиллагаа нь сэргэж хэвийн явагдах болсон ХК нь арилжаагаа сэргээхээр ирүүлсэн хүсэлтэд компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг хууль, журамд нийцүүлэн зарлан хуралдуулсныг нотлох баримт, хурлын шийдвэр, тэмдэглэл, хэлэлцсэн асуудлын талаарх тайлан, дүгнэлт, үүний дотор үйл ажиллагаа нь зогссон, хувь нийлүүлэгчдийн хурлыг хэд хэдэн жил хуралдуулаагүй шалтгаан, үйл ажиллагааг сэргээх төсөл, уг төсөлд цаашид эрхлэн явуулахаар төлөвлөж буй бизнес төлөвлөгөө, түүний төсөв, үр ашгийн

тооцоо санхүүгийн эх үүсвэрийн талаар судалгааг ирүүлсэн байх;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 35 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

б/үйл ажиллагаа нь сэргэн явагдаж эхэлснийг нотлох санхүүгийн тайлан, татварын байгууллагын болон орон нутагт бүртгэлтэй компанийн хувьд Хорооны орон нутгийн төлөөлөгчийн тодорхойлолтыг хавсаргасан байх;

в/Улаанбаатар хотод бүртгэлтэй компанийн хувьд ирүүлсэн бичиг баримт нь бодит байдалд нийцэж байгаа эсэхийг тогтоохоор газар дээр нь үзлэг хийж, дүгнэлт гаргасан байх.

г/Үйл ажиллагаагаа сэргээхийн тулд шинэ хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах замаар санхүүжилт татах бол тэдгээртэй байгуулсан гэрээ, санхүүжилт нь хууль ёсны орлогоос бүрдсэнийг нотолсон баримтыг Хороонд ирүүлнэ;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 35 дугаар тогтоолоор нэмсэн/*

д/Шинэ хөрөнгө оруулагч нь цаашид компанийн хувьцааны хяналтын багцыг эзэмшихээр гэрээн тусгасан бол тэдгээр нь Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйл болон Хорооноос баталсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-д заасны дагуу хяналтын багцыг худалдан авах саналаа зарлах хүсэлтийг арилжаа сэргээх хүсэлтийн хамт ирүүлсэн байна;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 35 дугаар тогтоолоор нэмсэн/*

е/ Компанийг өөрийн хөрөнгөөр болон хувьцаа эзэмшигчдийн хөрөнгөөр санхүүжүүлэх бол санхүүгийн эх үүсвэрийг нотолсон баримт, санхүүгийн тайлан, аудиторын дүгнэлт, үнэлгээчний тайлан, үл хөдлөх хөрөнгө болон өмчлөх эрхийн гэрчилгээ;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 35 дугаар тогтоолоор нэмсэн/*

4.2.Хувь нийлүүлэгчдийн хурлаар компанийг өөрчлөн байгуулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, үнэт цаасаа бүртгэлээс хасуулах хүсэлтээ ирүүлсэн ХК-иудын хувьд дараах шаардлагыг хангасан тохиолдолд Хорооны хуралдаанд санал оруулах:

а/Хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам”-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэн, холбогдох баримтыг ирүүлсэн байх, үүний дотор эрх бүхий үнэлгээний байгууллагаар компанийн бизнесийн үнэлгээг хийлгэн, хувьцаагаа эргүүлэн худалдаж авах үнийг хуульд нийцүүлэн тогтоосон байх;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 35 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

б/ХХК-д хувь нийлүүлэгчээр үлдэх хүсэлтээ гаргаагүй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг эргүүлэн худалдан авах баталгаа хөрөнгийг ҮЦТТТХТ-д шилжүүлсэн байх.

4.3.Компанийг татан буулгахаар шийдвэрлэж, хувьцаагаа бүртгэлээс хасуулах хүсэлтээ ирүүлсэн ХК-иудын хувьд дараах шаардлагыг хангасан тохиолдолд Хорооны хуралдаанд санал оруулах:

а/энэ тухайгаа нийтэд зарлан мэдээлж, татан буулгах үйл ажиллагааг Компанийн

тухай хуулийн холбогдох зүйлд заасны дагуу гүйцэтгэж, дуусгалтын баланс гарган, татан буулгах комиссын тайланг ирүүлэх;

б/хувь нийлүүлэгчдэд оногдох хөрөнгийг ҮЦТТХТ-д шилжүүлсэн байх шаардлага тавих.

5.Арилжаа нь зогссон компанийн хяналтын багц хувьцааг нэгдмэл сонирхолтой эзэмшиж байгаа этгээд нь хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэгүйгээс эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрхгүй болсон тохиолдолд дараах журмыг тогтоосугай:

а/хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахад саналын эрхтэй хувьцааны тооноос тооцож, ирцийн хувийг тодорхойлох;

б/энэ тогтоолын 4.1-д заасны дагуу арилжааг сэргээсэн үед хуульд заасан журмын дагуу тендер санал гаргах хүсэлтээ Хороонд ирүүлсэн бол тендер саналын хугацаа дууссаны дараа ирүүлсэн тайланг хянаад, хувьцааны саналын эрх сэргээсэн эсэх тухай дүгнэлтийг Ажлын алба Хороонд оруулж шийдвэрлүүлэх;

в/саналын эрхгүй болсон хувьцааг ямар нэг хэлбэрээр бусдад шилжүүлсэн тохиолдолд шилжүүлсэн хувьцаа саналын эрхгүй байх;

г/компанийг өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд хувьцааны саналын эрхийг сэргээх асуудлыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх;

д/татан буулгахаар шийдвэрлэсэн тохиолдолд хувьцаанд оногдох хөрөнгийг бусад хувьцааны нэгэн адилаар шийдвэрлэж байх.

6.Арилжаа нь зогссон ХК хувь нийлүүлэгчдийн хурлаа хуралдуулж, Төлөөлөн удирдах зөвлөлөө хуульд нийцүүлэн сонгож, цаашдын арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн үед үйл ажиллагаагаа сэргээн явуулах, эсхүл компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор үл хөдлөх хөрөнгийг барьцаалах, худалдах зэргээр бусдад шилжүүлэх шийдвэр гаргасан бөгөөд энэ асуудлаар Хороонд хандаж лавлагaa хүссэн тохиолдолд хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл бол уг хэлцлийг хуулийн дагуу хийсэн эсэх зэргийг хууль, журмын дагуу хянаад үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх, худалдах, барьцаалах шийдвэрийг хуульд нийцүүлэн гаргасан гэж үзвэл Ажлын алба лавлагaa мэдээлэл өгч байх, бусад тохиолдолд эдгээр компанийн үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой шийдвэрийн талаар аливаа лавлагaa, тодорхойлолт өгөхгүй байх журам тогтоосугай.

7. 2009 оны 1 дүгээр улиралд багтаан арилжаа зогсоосон арга хэмжээний үр дүнг гаргаж, Хороонд мэдээлэхийг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т даалгасугай.

8. Энэ тогтоолыг нийтэд сурталчлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН